



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

Барилгын тусгай зөвшөөрлийг сунгах,
нэмэлт ажлын төрлөөр олгох, шинээр
олгох, дахин олгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6 дахь заалт, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь заалт, Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ-ын Ерөнхийлөгчийн тушаалаар томилогдсон Ажлын хэсэг-ийн 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 26/21 дүгээр хуралдааны тэмдэглэл, дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдүгээр хавсралтад заасан 8 аж ахуйн нэгж, байгууллагад хавсралтад заасан барилгын ажлын төрлөөр 5 жилийн хугацаагаар тусгай зөвшөөрлийг сунгасугай.


2. Хоёрдугаар хавсралтад заасан 8 аж ахуйн нэгж, байгууллагад хавсралтад заасан барилгын ажлын төрлөөр тусгай зөвшөөрлийг нэмэлт ажлын төрлөөр олгосугай.

3. Гуравдугаар хавсралтад заасан 7 аж ахуйн нэгж, байгууллагад хавсралтад заасан барилгын ажлын төрлөөр 5 жилийн хугацаагаар тусгай зөвшөөрлийг шинээр олгосугай.

4. Барилгын үйл ажиллагаа эрхэлж буй "Хонгорын чулуу" ХХК-ийн оноосон нэрийг "Алтай сайхан өргөө констракшн" ХХК болгон өөрчилж, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгосугай.

5. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т даалгасугай.

6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ /Д.Цэрэнжигмэд/-д даалгасугай.



Б.МӨНХБААТАР

151030605

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн
196 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**А. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ:**

1. "Эй жи зэт" ХХК, Барилга угсралт, сунгалт БА-2.1, 5.4, 6.1, 6.2, 6.3, 6.4, 7.1 дүгээр ажлын төрлөөр;
2. "Их мандал" ХХК, Барилга угсралт, сунгалт БА-2.1, 6.3, 6.4, 7.1 дүгээр ажлын төрлөөр;
3. "Дельта констракшн" ХХК, Барилга угсралт, сунгалт БА-2.1, 4.1, 7.1 дүгээр ажлын төрлөөр;
4. "Элит констракшн" ХХК, Барилга угсралт, сунгалт БА-4.1, 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр ажлын төрлөөр;
5. "Классик хаус" ХХК, Зураг төсөл, сунгалт ЗТ-2.1, 3.1, 3.3, 3.5, 4.1, 4.3, 6.1, 6.2, 6.3, 6.4, 8.1, 10.2 дугаар ажлын төрлөөр;
6. "Наран рашаан" ХХК, Зураг төсөл, сунгалт ЗТ-2.1, 4.4, 10.2 дугаар ажлын төрлөөр;
7. "Улаан толгой хайрхан" ХХК, Зураг төсөл, сунгалт ЗТ-4.1, 4.3, 4.8, 4.9, 4.10, 6.1, 6.2, 6.3, 6.4, 8.1, 10.2 дугаар ажлын төрлөөр;
8. "Тиймворк визуал" ХХК, Зураг төсөл, сунгалт ЗТ-4.1, 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр ажлын төрлөөр.

----oOo----

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 19 дугаар сарын 15-ны өдрийн
196 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Б. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НЭМЭЛТ АЖЛЫН ТӨРӨЛ ОЛГОХ:**

1. "МДТОФ" ХХК, Барилга угсралт, нэмэлт БА-7.1 дүгээр ажлын төрлөөр;
2. "Баттөгс хийц" ХХК, Барилга угсралт, нэмэлт БА-4.1 дүгээр ажлын төрлөөр;
3. "Инфинити пийк" ХХК, Барилга угсралт, нэмэлт БА-4.1 дүгээр ажлын төрлөөр;
4. "Гэрчулуу даваа" ХХК, Барилга угсралт, нэмэлт БА-3.5 дугаар ажлын төрлөөр;
5. "Ай энд жи дизайн" ХХК, Зураг төсөл, нэмэлт ЗТ-4.1 дүгээр ажлын төрлөөр;
6. "Магнус сентурион констракшн" ХХК, Зураг төсөл, нэмэлт ЗТ-6.2 дугаар ажлын төрлөөр;
7. "Кью Эм Си" ХХК, Зураг төсөл, нэмэлт ЗТ-4.7 дугаар ажлын төрлөөр;
8. "МОГҮМБ констракшн" ХХК, Зураг төсөл, нэмэлт ЗТ-5.1 дүгээр ажлын төрлөөр (УБ, ХУД, 15-р хорооны нутаг дэвсгэрт баригдахаар төлөвлөгдөж буй 17 давхар "Бүти таун" үйлчилгээтэй орон сууцны барилгын зураг төслийн ажил).

----oOo----

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 19 дугаар сарын 15-ны өдрийн
196 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**В. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ:**

1. “Аркейд дизайн” ХХК, Зураг төсөл, шинэ ЗТ-2.1 дүгээр ажлын төрлөөр;
2. “Маргад мөрөн” ХХК, Зураг төсөл, шинэ ЗТ-2.1 дүгээр ажлын төрлөөр;
3. “Маргад мөрөн” ХХК, Барилга угсралт, шинэ БА-2.1 дүгээр ажлын төрлөөр;
4. “Адептио” ХХК, Барилга угсралт, шинэ БА-6.1, 6.2 дугаар ажлын төрлөөр;
5. “Баттөгс ар констракшн” ХХК, Барилга угсралт, шинэ БА-2.1, 6.4 дүгээр ажлын төрлөөр;
6. “Эрхэт аз алтай” ХХК, Барилга угсралт, шинэ БА-6.3 дугаар ажлын төрлөөр;
7. “Эдвэнсэд констрактор, Барилга угсралт, шинэ БА-2.1 дүгээр ажлын төрлөөр.

-----oOo-----